



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
УЛААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 01 сарын 31 өдөр

Дугаар А/08

Төгөл

Бүх нийтийн хог цэвэрлэгээний ажлыг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.1, 9.4.5 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Уламжлалт цагаан сарын баярыг төвийн өнгө үзэмжийг сайжруулах, ард иргэдийн ажиллах, амьдрах цэвэр орчинг бүрдүүлэх зорилгын хүрээнд бүх нийтийн хог цэвэрлэгээний ажлыг 2024 оны 02 дугаар сарын 01-ний өдөр "Пүрэв гариг"-т зохион байгуулсугай.

2. Заасан хугацаанд аж ахуйн нэгж, байгууллагууд өөрсдийн эзэмшил газруудын хог хаягдлыг бүрэн цэвэрлэж, тээвэрлэж ажиллахыг албан байгууллагын дарга, эрхлэгч нар, Аж ахуйн нэгжийн эздэд тус тус үүрэг болгосугай.

3. Бүх нийтийн хог цэвэрлэгээний ажилд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудыг татан оролцуулж, үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Төгөл багийн Засаг дарга (Т.Амарсайхан)-д, хог цэвэрлэгээний ажилд идэвхтэй оролцож, өөрийн эзэмшил газрын хог хаягдлыг цэвэрлэж, хоггүй орчин бүрдүүлж ажиллахыг сумын нийт ард иргэдэд тус тус үүрэг болгосугай:

4. Зохион байгуулж буй ажилд шаардлагатай техник хэрэгсэл, бензин шатахуун, бусад зүйлээр хангаж ажиллахыг Тамгын газрын дарга (М.Батцогт)-д, нягтлан бодогч (Т.Намжилсүрэн)-д, Нярав (Ч.Хүнбиш) нарт тус тус даалгасугай.

5. Иргэд, олон нийтэд сайтар сурталчилж, хог цэвэрлэгээний ажилд идэвхгүй оролцсон иргэн аж ахуйн нэгж, байгууллагуудад холбогдох хуулийн дагуу хяналт тавьж, хариуцлага тооцон ажиллахыг Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн (Г.Батчимэг), Төгөл багийн Засаг дарга (Т.Амарсайхан), Байгаль хамгаалагч (Н.Батбаясах), (Ө.Нямгэрэл) нарт тус тус үүрэг болгосугай.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллахыг Тамгын газрын дарга (М.Батцогт)-д даалгасугай.

ОРЛОГЧ

М.ОТГОНБААТАР

